



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 719

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар их сургуулийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2021 онд нийт 167,729,500.00 (нэг зуун жаран долоон сая долоон зуун хорин есөн мянга таван зуун) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, санхүүжилтийн дүн, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Улаанбаатар их сургуулийн захирал С.Байгалсайханд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201700

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 12 дугаар сарын 28 ны өдрийн
 71.9 дугаар тогтоолын хавсралт

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНД ХУДАЛДАН АВАХ
 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Санхүүжих дүн, худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1.Барилга байгууламж (их засвар)					
1	Сантехникийн их засвар	багц	1	-	80,000,000.00
	Дүн				80,000,000.00
2.Тоног төхөөрөмж (сургалтын)					
1	Компьютер (DELL)	ш	15	1,500,000.00	22,500,000.00
2	Компьютер	ш	3	2,250,000.00	6,750,000.00
3	Компьютер	ш	10	1,250,000.00	12,500,000.00
4	Принтер	ш	3	462,000.00	1,386,000.00
5	Хард	ш	2	892,000.00	1,784,000.00
6	Зөөврийн компьютер /Нөтбүк/	ш	5	1,500,000.00	7,500,000.00
7	Принтер /Өнгөт/	ш	1	1,309,500.00	1,309,500.00
	Дүн				53,729,500.00
3.Тавилга,эд хогшил, бусад хөрөнгө					
1	Ангийн самбар /хөлтэй/	ш	5	2,625,000.00	13,125,000.00
2	Ширээ /багш/	ш	10	640,000.00	6,400,000.00
3	Сандал /багш/	ш	10	220,000.00	2,200,000.00
4	Архивын шат	ш	1	1,360,000.00	1,360,000.00
5	Номын сангийн тавиур	ш	1	915,000.00	915,000.00
6	Ном /номын сангийн баяжилт/	ш	багц	-	10,000,000.00
	Дүн				34,000,000.00
	Нийт дүн				167,729,500.00 (нэг зуун жаран долоон сая долоон зуун хорин есөн мянга таван зуун)